

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2.	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.12.	Шилэн дансны мэдээлэл.....	6
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3.	Менежментийн захидал.....	8
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2.	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3.	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4.	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5.	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МУДШ	Монгол Улсын Дээд шүүх
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Х.БАТСҮРЭН  
ТАНАА

2020 04.24 № 1324  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон УСНББОУС, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Х.Батсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, авлага, өр төлбөргүй байх, урьдчилж гарсан зардал данстай холбоотой асуудлыг шийдвэрлэх, мөрдөж байгаа эрх зарим зүйн актыг боловсронгуй болгох, бараа материалыг данснаас хасах шийдвэр гарсны дараа актлах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 10-аас 2020 оны 04 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Цэрэнхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Б/1044 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагаас баримтлах бодлого, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Монгол Улсын Дээд шүүхийн эрхэм зорилгыг Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульд байгууллагыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоох, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Монгол Улсын Дээд шүүхийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Интерактив” программ хангамж ашигладаг ба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Улсын Дээд шүүхийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,813.2 сая төгрөгөөс тооцон 76.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төлөвлөгөө боловсруулах үед 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан эцэслэж, хүргэгдээгүй байснаас шалтгаалан гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,153.8 сая төгрөгийн 2.0 хувиар тооцож 123.1 сая төгрөгөөр тогтоолоо.

## 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улсын Дээд шүүхийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,677.0 сая төгрөгөөр буюу 211.4 хувиар өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая-төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>366.2</b>	<b>380.4</b>	<b>14.2</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	10.0	7.6	( 2.4)
Урьдчилгаа	37.0	37.0	-
Бараа материал	319.2	335.8	16.6
<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>2,934.4</b>	<b>6,597.2</b>	<b>3,662.8</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,300.6</b>	<b>6,977.6</b>	<b>3,677.0</b>
Өр төлбөр	-	0.1	0.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,300.6	6,977.5	3,676.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,300.6</b>	<b>6,977.6</b>	<b>3,677.0</b>

Улсын Дээд шүүхийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт хөрөнгийн дүн 3,677.0 сая төгрөгөөр, эргэлтийн хөрөнгө 14.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө 3,662.8 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Авлага оны эхэнд 10.0 сая төгрөг байсан бол оны эцэст 7.6 сая төгрөг болж 2.4 сая төгрөгөөр буурсан бөгөөд авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материал оны эхэнд 319.2 сая төгрөг байсан бол оны эцэст 335.8 сая төгрөг болж, 144.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 99.3 сая төгрөгийн бараа, материал зарцуулж, 28.2 сая төгрөгийн бараа материал акталж, данснаас хассантай холбоотой байна.

2019 онд хөрөнгө оруулалтын зардалд 4,000.0 сая төгрөг батлагдаж, конторын барилгын дээвэр, фасад, дотор өрөөний их засварын ажлуудыг хийж, барилга байгууламжийн үнэ 1,878.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тээврийн хэрэгсэл 1,046.5 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 543.2 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 432.7 сая төгрөгөөр тус тус худалдан авсан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 648, 649 дугаар тогтоолоор тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 49.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж, тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 103.1 сая төгрөгийн хөрөнгийг данснаас дансанд шилжүүлсэн байна.

## **2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны урсгал зардалд зориулан 5,967.1 сая, хөрөнгийн зардалд 4,000.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 5,967.1 сая, хөрөнгийн зардалд 3,847.4 сая төгрөгийн санхүүжилт авч төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны хүрээнд 8.2 сая, бусад орлогоос 2.5 сая төгрөг, нийт 9,825.2 сая төгрөгийг бүрдүүлж, урсгал зардалд 4,616.7 сая, хөрөнгийн зардалд 3,830.2 сая төгрөгийг зарцуулж 1,378.3 сая төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэлтэй асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 1,430.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,350.4 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 80.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан дахь эхний болон эцсийн үлдэгдлийг тулган баталгаажуулах явцад төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлэх бичилт хийхгүйгээр тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн

Аудитаар илэрсэн 80.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг Менежментийн захидалд тусгалаа.

### **2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал гараагүй.

### **2.12 Шилэн дансны мэдээлэл**

Монгол Улсын Дээд шүүх тайлант онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 35 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

### **2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Авлага барагдуулах, үндсэн хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, автомашины техникийн комиссын ажиллах журам баталж мөрдөх, үнэлгээний хорооны даргыг хууль эрх зүйд нийцүүлж томилох зэрэг асуудалтай холбоотой 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС, СТА хийх журам, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал:**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

2011 онд хийлгэсэн Сургалтын төвийн барилгын зураг төсвийн үнэ 36.9 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн боловч өнөөг хүртэл уг барилга баригдаагүй, зураг төсвийг ашиглаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх, мөрдөж ажиллаагүй байх;

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Сургалтын төвийн барилгыг уг зураг төсвөөр баригдах, эсэх асуудлыг ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлэх

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### **3.2. Цалингийн зардалтай холбоотой асуудал:**

##### **3.2.1. Илрүүлэлт:**

Цалинтай холбоотой баримтыг түүвэрлэн шалгахад ажиллагсдад цалинтай чөлөөг хэт олон хоногоор буюу ажлын 15-22 хоногоор тооцож 7.3 сая төгрөгийг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Монгол Улсын Ерөнхий шүүгчийн 2015 оны 49 дүгээр захирамжаар баталсан "Улсын Дээд шүүхийн Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.5-д "Ажлын 3-аас дээш хоногийн чөлөөг харьяалах хэлтэс, албаны даргын саналыг үндэслэн Тамгын газрын дарга шийдвэрлэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.2.2. Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль эрх зүйн заалт зөрчигдөх;

##### **3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Ажиллагсдад чөлөө олгохдоо хэдэн өдөрт нь цалинтай ба цалингүй чөлөө олгох талаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тодорхой заалт оруулах

**3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**3.3. Балансын данстай холбоотой асуудал**

**3.3.1. Илрүүлэлт:**

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тулган шалгахад авлага өмнөх оноос буурсан боловч өмнөх оноос дамжиж ирсэн 7.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**3.3.2. Эрсдэл:**

Найдваргүй авлага, өр төлбөр үүсэх, холбогдох хууль эрх зүйн заалт зөрчигдөх;

**3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийг зохистой удирдаж оны эцэст авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

**3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**3.4. Балансын данстай холбоотой асуудал**

**3.4.1. Илрүүлэлт:**

Санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган шалгахад 28.2 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын удирдлагын шийдвэргүйгээр акталж, данснаас хассан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д "Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл санал, дүгнэлт гаргасан байх" гэж заасантай нийцэхгүй байна.

**3.4.2. Эрсдэл:**

Бараа материал үрэгдэх, холбогдох эрх зүйн заалт зөрчигдөх

**3.4.3. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн байгууллагын удирдлагын тушаал, шийдвэрээр бараа материалыг акталж, данс бүртгэлээс хасаж байх.

**3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор албан бичгээр ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Балансын зүйл	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>366,219.1</b>	<b>380,449.2</b>
<b>АВЛАГА</b>	<b>10,048.7</b>	<b>7,670.0</b>
Бусад авлага		
Байгууллагаас авах авлага	10,048.7	7,670.0
<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>36,965.6</b>	<b>36,965.6</b>
Урьдчилж гарсан зардал	36,965.6	36,965.6
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>319,204.8</b>	<b>335,813.6</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>319,204.7</b>	<b>335,813.6</b>
Бичиг хэргийн материал	67,870.3	70,214.6
Аж ахуйн материал	119,512.9	102,871.7
Сэлбэг хэрэгсэл	250.0	250.0
Түлш, шатах тослох материал	50,192.2	38,272.0
Хүнсний материал	1,872.5	2,123.6
Бусад хангамжийн материал	79,506.8	122,081.7
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,934,370.3</b>	<b>6,597,180.6</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,934,370.3</b>	<b>6,597,180.6</b>
Биет хөрөнгө	2,643,391.2	6,311,474.1
Барилга, байгууламж, орон сууц	2,343,919.3	4,222,563.3
Хуримтлагдсан элэгдэл	-18,687.0	-115,067.6
Авто-тээврийн хэрэгсэл	984,972.8	1,928,326.6
Хуримтлагдсан элэгдэл	-962,557.5	-884,090.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	569,961.8	1,064,022.5
Хуримтлагдсан элэгдэл	-420,062.2	-454,841.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	420,689.1	853,432.3
Хуримтлагдсан элэгдэл	-275,762.0	-303,119.4
Бусад үндсэн хөрөнгө	13,744.6	13,194.6
Хуримтлагдсан элэгдэл	-12,827.7	-12,946.3
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>290,979.1</b>	<b>285,706.4</b>
Программ хангамж	27,394.4	27,944.4
Хуримтлагдсан элэгдэл	-16,320.4	-22,143.1
Бусад биет бус хөрөнгө	279,905.1	279,905.1
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,300,589.4</b>	<b>6,977,629.8</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.0</b>	<b>119.3</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.0</b>	<b>119.3</b>
<b>Өглөг</b>	<b>0.0</b>	<b>119.3</b>
Бусад өглөг	0.0	119.3
Байгууллагад төлөх өглөг	0.0	19.3
Ажиллагсадтай холбоотой өглөг	0.0	100.0
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,300,589.4</b>	<b>6,977,510.5</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,300,589.4</b>	<b>6,977,510.5</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,428,220.1	1,428,220.1
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>472,533.0</b>	<b>4,149,454.0</b>
Өмнөх үеийн үр дүн	-355,646.5	472,532.9
Тайлант үеийн үр дүн	828,179.5	3,676,921.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,399,836.3	1,399,836.3
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,300,589.4</b>	<b>6,977,629.8</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,641,436.1</b>	<b>9,830,724.8</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>637,887.2</b>	<b>7,998.3</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>637,887.2</b>	<b>7,998.3</b>
Төсөвт байгууллагын өөрийн орлого		-
Бусад орлого	784.0	7,998.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	637,103.2	-
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,003,548.9</b>	<b>9,822,726.5</b>
<b>Татаас санхүүжилтийн орлого</b>	<b>3,998,145.9</b>	<b>9,814,526.5</b>
Улсын төсвөөс санхүүжих	3,998,145.9	9,814,526.5
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,403.0</b>	<b>8,200.0</b>
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,403.0	8,200.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,813,256.6</b>	<b>6,153,803.7</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,813,256.6</b>	<b>6,153,803.7</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,469,552.1</b>	<b>3,485,558.3</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,366,358.5</b>	<b>2,382,474.3</b>
Үндсэн цалин	2,362,947.3	2,326,849.3
Нэмэгдэл цалин	3,411.2	-
Унаа хоолны хөнгөлөлт	-	55,624.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>280,453.0</b>	<b>298,366.9</b>
Тэтгэврийн даатгал	194,923.0	298,366.9
Тэтгэмжийн даатгал	23,407.3	-
ҮОМШ өвчний даатгал	10,626.7	-
Ажилгүйдлийн даатгал	4,681.5	-
Эрүүл мэндийн даатгал	46,814.6	-
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,103.1</b>	<b>75,118.8</b>
Гэрэл цахилгаан	20,946.6	26,052.2
Түлш, халаалт	24,985.8	28,438.1
Цэвэр, бохир ус	3,210.7	3,375.5
Байрны түрээс	20,960.00	17,253.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>86,091.8</b>	<b>77,348.4</b>
Бичиг хэрэг	26,363.2	23,843.4
Тээвэр шатахуун	36,302.0	30,270.0
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	18,937.1	16,164.6
Ном, хэвлэл	4,140.5	4,554.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,400.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	349.0	115.5
<b>Нормативт зардал</b>	<b>79.8</b>	<b>-</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79.8	-
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,791.5</b>	<b>28,808.3</b>
Урсгал засвар	25,791.5	28,808.3
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>131,362.0</b>	<b>129,803.5</b>
Дотоод албан томилолт	131,362.0	126,689.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	3,113.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>81,636.3</b>	<b>96,147.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,357.8	5,036.7
Даатгалын үйлчилгээ	49,080.4	52,298.7
Тээврийн хэрэгслийн татвар	1,097.6	1,315.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	319.0	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,281.2	24,183.5
Газрын төлбөр	9,500.3	13,312.7

<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>427,676.0</b>	<b>397,490.4</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	39,204.2	66,945.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	164,592.6	92,219.1
Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	223,879.2	238,325.5
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>343,704.5</b>	<b>2,668,245.4</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,565.9</b>	<b>,290,140.4</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,296.9	383,594.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,269.0	906,546.2
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>297,138.6</b>	<b>1,378,105.0</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	296,064.3	1,352,905.0
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх, шилжүүлэг	1,074.3	8,200.0
Улсын төсвийн орлогд төвлөрүүлэх	-	17,000.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>828,179.5</b>	<b>3,676,921.1</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	<b>828,179.5</b>	<b>3,676,921.1</b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,003,548.9</b>	<b>9,825,236.3</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,403.0</b>	<b>10,709.8</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,403.0</b>	<b>10,709.8</b>
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,403.0	8,200.0
Бусад орлого	-	2,509.8
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,998,145.9</b>	<b>9,814,526.5</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,998,145.9</b>	<b>9,814,526.5</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,998,145.9	5,967,104.0
Хөрөнгийн санхүүжилт		3,847,422.5
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,900,425.4</b>	<b>5,924,100.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,900,425.4</b>	<b>5,924,100.6</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,557,091.9</b>	<b>3,256,541.0</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,335,608.3</b>	<b>2,332,237.5</b>
Үндсэн цалин	1,665,280.6	1,622,790.2
Нэмэгдэл	490,688.8	561,889.9
Унаа хоолны Хөнгөлөлт	159,625.4	116,915.9
Урамшуулал	20,013.5	30,641.4
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>310,904.4</b>	<b>349,762.9</b>
Тэтгэврийн даатгал	310,904.4	349,762.9
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,103.1</b>	<b>75,118.8</b>
Гэрэл, цахилгаан	20,946.6	26,052.2
Түлш, халаалт	24,985.8	28,438.1
Цэвэр, бохир ус	3,210.7	3,375.5
Байрны түрээс	20,960.0	17,253.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>146,078.6</b>	<b>98,264.9</b>
Бичиг хэрэг	39,683.4	33,806.8
Тээвэр, шатахуун	40,400.0	20,200.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,937.1	16,141.5
Ном, хэвлэл	4,183.6	5,349.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,874.5	22,766.7
<b>Нормативт зардал</b>	<b>4,656.9</b>	<b>0.0</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,656.9	0.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>285,247.9</b>	<b>75,117.8</b>
Багаж, техник, хэрэгсэл	4,358.5	29,049.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,656.5	2,695.2
Урсгал засвар	278,232.9	43,372.7
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>162,427.8</b>	<b>133,904.6</b>

Дотоод албан томилолт	161,571.0	126,419.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	856.8	7,485.4
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>96,114.0</b>	<b>99,204.9</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,266.00	9,597.9
Даатгалын үйлчилгээ	50,497.0	50,560.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,171.4	29,777.1
Газрын төлбөр	9,180.3	9,269.9
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>145,950.2</b>	<b>92,929.5</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,977.2	3,295.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	140,973.0	89,634.3
<b>ТАТААС</b>	<b>343,333.5</b>	<b>2,667,559.6</b>
Татаас шилжүүлэг	297,138.6	1,378,105.0
Төвлөрүүлэх шилжүүлэг	296,064.3	1,352,905.0
Нэмэлт санхүүжилтийн данс	1,074.3	8,200.0
Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх	0.0	17,000.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>46,194.9</b>	<b>1,289,454.6</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,194.9</b>	<b>1,289,454.6</b>
Бусад мөнгөн зарлага	-	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,296.9	383,594.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,898.0	905,860.4
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>103,123.5</b>	<b>3,901,135.7</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>103,123.5</b>	<b>3,901,135.7</b>
Биет ба биет бус хөрөнгө оруулалтын зардал	103,123.5	3,901,135.7
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-103,123.5</b>	<b>-3,901,135.7</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,148,315.0</b>	<b>138,528.8</b>	<b>(355,646.5)</b>	<b>931,197.3</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,148,315.0	138,528.8	(355,646.5)	931,197.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	1,261,307.5	-	1,261,307.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	828,179.5	828,179.5
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	279,905.1	-	-	279,905.1
Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-	-
<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,428,220.1</b>	<b>1,399,836.3</b>	<b>472,532.9</b>	<b>3,300,589.4</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,428,220.1	1,399,836.3	472,532.9	3,300,589.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	3,676,921.1	3,676,921.1
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-	-
<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,428,220.1</b>	<b>1,399,836.3</b>	<b>4,149,454.0</b>	<b>6,977,510.5</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,967,104.0</b>	<b>4,616,708.8</b>	<b>1,350,395.2</b>	<b>77.4</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,967,104.0</b>	<b>4,616,708.8</b>	<b>1,350,395.2</b>	<b>77.4</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,171,866.3</b>	<b>3,327,254.2</b>	<b>844,612.1</b>	<b>79.7</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,797,273.1</b>	<b>2,332,237.5</b>	<b>465,035.6</b>	<b>83.4</b>
Үндсэн цалин	1,921,265.9	1,622,790.2	298,475.7	84.5
Нэмэгдэл цалин	682,072.4	561,889.9	120,182.5	82.4
Унаа хоолны Хөнгөлөлт	159,625.4	116,915.9	42,709.4	73.2
Урамшуулал	34,309.4	30,641.4	3,668.0	89.3
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>349,762.9</b>	<b>349,762.9</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
Тэтгэврийн даатгал	349,762.9	349,762.9	0.0	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>86,261.3</b>	<b>75,118.8</b>	<b>11,142.5</b>	<b>87.1</b>
Гэрэл, цахилгаан	27,456.6	26,052.2	1,404.4	94.9
Түлш, халаалт	28,510.3	28,438.1	72.1	99.7
Цэвэр, бохир ус	8,729.4	3,375.5	5,353.9	38.7
Байрны түрээс	21,565.0	17,253.0	4,312.0	80.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>180,377.00</b>	<b>98,264.89</b>	<b>82,112.11</b>	<b>54.48</b>
Бичиг хэрэг	43,563.8	33,806.8	9,756.9	77.6
Тээвэр, шатахуун	37,255.3	20,200.8	17,054.5	54.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,582.4	16,141.5	35,440.9	31.3
Ном, хэвлэл	25,090.3	5,349.0	19,741.3	21.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,885.2	22,766.7	118.5	99.5
<b>Нормативт зардал</b>	<b>4,656.9</b>	<b>0.0</b>	<b>4,656.9</b>	<b>-</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,656.9	0.0	4,656.9	-
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>206,674.6</b>	<b>145,830.9</b>	<b>60,843.6</b>	<b>70.6</b>
Багаж, техник, хэрэгсэл	42,075.0	42,030.3	44.7	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,156.5	2,695.2	461.3	85.4
Урсгал засвар	161,443.1	101,105.4	60,337.6	62.6
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>162,476.6</b>	<b>133,904.6</b>	<b>28,572.0</b>	<b>82.4</b>
Дотоод албан томилолт	126,419.8	126,419.2	0.6	100.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	36,056.8	74,854.0	28,571.4	20.8
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>238,041.5</b>	<b>99,204.9</b>	<b>138,836.5</b>	<b>41.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,364.4	9,597.9	9,766.5	49.6
Даатгалын үйлчилгээ	69,270.0	50,560.1	18,709.9	72.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	137,137.2	29,777.1	107,360.1	21.7
Газрын төлбөр	12,269.9	9,269.9	3,000.0	75.5
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>146,342.4</b>	<b>92,929.5</b>	<b>53,412.9</b>	<b>63.5</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,977.2	3,295.2	1,681.9	66.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	141,365.2	89,634.3	51,730.9	63.4
<b>ТАТААС</b>	<b>1,795,237.7</b>	<b>1,289,454.6</b>	<b>505,783.1</b>	<b>71.8</b>
Татаас шилжүүлэг	1,795,237.7	1,289,454.6	505,783.1	71.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,795,237.7</b>	<b>1,289,454.6</b>	<b>505,783.1</b>	<b>71.8</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,795,237.7</b>	<b>1,289,454.6</b>	<b>505,783.1</b>	<b>71.8</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	888,787.7	383,594.1	505,193.6	43.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	906,450.0	905,860.4	589.5	99.9
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>9,967,104.0</b>	<b>8,464,131.0</b>	<b>1,519,972.7</b>	<b>84.9</b>
Урсгал санхүүжилт	5,967,104.0	4,616,708.8	1,350,395.2	77.4



Хөрөнгийн санхүүжилт	4,000,000.0	3,847,422,5	169,577.5	96,2
<b>Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт</b>	-	-	-	-
Байгууллагын тоо	1	1		100.0
Ажиллагсдын тоо	129	106	23	82.2
Удирдах ажилтан	10	10		100.0
Гүйцэтгэх ажилтан	89	73	16	82.0
Үйлчилгээний ажилтан	30	23	7	76.7

## 5 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Огноо:	Аудитын нэр:	<i>2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан</i>	Аудитын код:
2020.02.20			САГ-2020/30/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр	Монгол Улсын Дээд шүүх		сая төгрөг

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
1 2011 онд Сургалтын төвийн барилгын зураг төсвийн үнэнд шилжүүлсэн мөнгийг өнөөг хүртэл урьдчилсан гарсан зардал дансанд бүртгэж ирсэн ба уг барилга баригдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", гэсэн заалттай нийцэхгүй байна.	36.9	Зөвлөмж	МУДШ-ийн Тамгын газрын дарга , Ерөнхий нягтлан бодогч	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
2 Цалинтай холбоотой баримтыг түүвэрлэн шалгахад ажиллагсад цалинтай чөлөөг хэт олон хоногоор буюу ажлын 15-22 хоногоор олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Монгол Улсын Ерөнхий шүүгчийн 2015 оны 49 дүгээр захирамжаар баталсан "Улсын Дээд шүүхийн Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.5-д "Ажлын 3-аас дээш хоногийн чөлөөг харьяалах хэлтэс, албаны даргын саналыг үндэслэн Тамгын газрын дарга шийдвэрлэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.	7.3	Зөвлөмж	МУДШ-ийн Тамгын газрын дарга , Ерөнхий нягтлан бодогч	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
3 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тулган шалгахад авлага өмнөх оноос буурсан боловч өмнөх оноос дамжиж ирсэн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.	7.7	Зөвлөмж	МУДШ-ийн Тамгын газрын дарга , Ерөнхий нягтлан бодогч	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
4 Санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган шалгах явцад бараа материалыг байгууллагын удирдлагын шийдвэргүйгээр акталж, данснаас хассан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д "Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл санал, дүгнэлт гаргасан байх" гэж заасантай нийцэхгүй байна.	28.1	Зөвлөмж	МУДШ-ийн Тамгын газрын дарга , Ерөнхий нягтлан бодогч	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
Зөвлөмжийн дүн	80.1			



